

“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2018 оны 6 дугаар сарын 13-ны өдөр

№13/15

Улаанбаатар хот

Компанийн бүтцэд өөрчлөлт оруулах, Эрх шилжүүлэхийг зөвшөөрөх тухай

Компанийн тухай хуулийн Компанийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.2 дахь хэсэг, 80 дугаар зүйлийн 80.3, 80.4 дэх хэсэг, 73 дугаар зүйл, Иргэний хуулийн 53 дугаар зүйл, 62 дугаар зүйл, 64 дүгээр зүйл, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн үйл ажиллагааны журмын 11.8 дахь хэсэг, “ЛэндМН ББСБ” ХК (“компани”)-ийн дүрмийн 9.6.10, 9.6.22 дахь заалт, ТУЗ-ийн эчнээ санал хураалтын дүнг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн ТУЗ-ийн 2018 оны 03 сарын 22-ны өдрийн 18/10 тоот тогтоолоор батлагдсан “Компанийн бүтэц, зохион байгуулалт”-д өөрчлөлт оруулж “Санхүү, үйл ажиллагаа хариуцсан дэд захирал” гэсэн 1 орон тоо буюу албан тушаалыг Гүйцэтгэх захирлын шууд удирдлага дор 2018 оны 5 дугаар сарын 21-ны өдрөөс эхлэн нэмж баталсугай.
2. Бүтцийн өөрчлөлтэй холбогдуулан тушаал шийдвэрийг гаргах, ажилтны бүрэн эрхийг тогтоож, түүнтэй гэрээ байгуулж, хяналт тавьж ажиллахыг Гүйцэтгэх захирал (Б.Дэлгэржаргал)-д үүрэг болгосугай.
3. Санхүү, үйл ажиллагаа хариуцсан дэд захирал нь Компанийн санхүү, нягтлан бодох бүртгэл, харилцагчийн бүртгэл, авлага барагдуулах үйл ажиллагааг удирдан ажиллахыг дурдсугай.
4. Санхүү, үйл ажиллагаа хариуцсан дэд захирал (М.Түвшинжаргал)-ын 2018 оны 5 дугаар сарын 21-ны өдрөөс хойших шийдвэр, үйл ажиллагааг хүчин төгөлдөр гэж үзсүгэй.
5. Компаниас харилцагчтай байгуулах “Цахим зээлийн эрх нээх гэрээ” болон бусад бүтээгдэхүүн үйлчилгээтэй холбоотой гэрээ байгуулах, гэрээнд гарын үсэг зурах эрхийг холбогдох албан тушаалтанд олгож ажиллахыг Гүйцэтгэх захирал (Б.Дэлгэржаргал)-д зөвшөөрсүгэй.
6. Компанийн өдөр тутмын үйл ажиллагаатай холбоотой 10'000'000 (арван сая) төгрөг хүртэлх үнийн дүнтэй гэрээ, хэлцэл байгуулах, гарын үсэг зурах эрхийг холбогдох албан тушаалтанд олгож ажиллахыг Гүйцэтгэх захирал (Б.Дэлгэржаргал)-д зөвшөөрсүгэй.
7. Компанийн өдөр тутмын мөнгөн хөрөнгийн гүйлгээ хийх, төлбөрийн баримтад гарын үсэг зурах эрхийг холбогдох албан тушаалтанд олгохыг Гүйцэтгэх захирал (Б.Дэлгэржаргал)-д зөвшөөрсүгэй.

ТУЗ-ИЙН ДАРГА

О.БОЛДБААТАР

**“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ**

2018 оны 08 сарын 01 -ны өдөр

№... 18/16

Улаанбаатар хот

Компанийн бүтцийг шинэчлэн батлах тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 заалт, 80 дугаар зүйл, “ЛэндМН ББСБ” ХК-ийн дүрмийн 9.6.10, 9.10 дугаар заалт, Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2018 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. “ЛэндМН ББСБ” ХК-ийн бүтэц, зохион байгуулалтыг 1 дүгээр хавсралтаар шинэчлэн баталсугай.
2. Компанийн бүтцийг шинэчлэн баталсантай холбогдуулан Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2018 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн 18/10 тоот тогтоолын 3 дугаар заалтыг, 3 дугаар хавсралтын хамт хүчингүй болсонд тооцсугай.
3. Батлагдсан бүтцийн хүрээнд үйл ажиллагааг зохион байгуулах, алба, хэлтэс, нэгж, албан тушаалтныг чиг удирдлагаар ханган, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг Гүйцэтгэх захирал /Б.Дэлгэржаргал/-д үүрэг болгосугай.
4. Компанийн үйл ажиллагаатай уялдуулан, зарим хэлтэс, алба, нэгжийн зохион байгуулалт, чиг үүрэгт өөрчлөлт оруулах шаардлагатай тохиолдолд хэлтэс, алба, нэгжийн нэршил болон харъяаллыг өөрчлөх эрхийг Гүйцэтгэх захирал /Б.Дэлгэржаргал/-д олгосугай.

ТУЗ-ИЙН ДАРГА



О.БОЛДБААТАР

**“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ**

2018 оны 08 сарын 01 -ны өдөр

№...18/12

Улаанбаатар хот

**2018 оны төлөвлөгөөнд
өөрчлөлт оруулах тухай.**

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 заалт, 80 дугаар зүйл, “ЛэндМН ББСБ” ХК-ийн дүрмийн 9.6.1, 9.10 дугаар заалт, Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2018 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2018 оны 03 сарын 22-ны өдрийн 18/10 тоот тогтоолоор батлагдсан “Үйл ажиллагааны төлөвлөгөө”-нд өөрчлөлт оруулж, 2018 оны үйл ажиллагааны шинэчилсэн төлөвлөгөөг Хавсралт 1-ээр баталсугай.
2. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах, төлөвлөгөөний дагуу үйл ажиллагаа явуулж, гүйцэтгэлийг тайлагнаж ажиллахыг Гүйцэтгэх захирал (Б.Дэлгэржаргал) –д үүрэг болгосугай.

ТУЗ-ИЙН ДАРГА



О.БОЛДБААТАР

“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2018 оны 9 дүгээр сарын 05-ны өдөр

№ 18/18

Улаанбаатар хот

Дотоод аудитор томилох тухай

Компанийн тухай хуулийн 76.1.18, 81.4.2 дахь хэсэг, ЛэндМН ББСБ ХК-ийн дүрмийн 14 дүгээр зүйлийн 14.5.2 дахь заалт, ТУЗ-ийн үйл ажиллагааны журмын 2 дугаар зүйлийн 2.9.4, 2.9.5 дахь заалт, ТУЗ-ийн дэргэдэх Аудитын Хорооны 2018 оны 8 дугаар сарын 09-ний өдрийн хурлын шийдвэр, ТУЗ-ийн эчнээ санал хураалтын дүнг үндэслэн тогтоох нь:

1. Компанийн Дотоод аудитор албан тушаалд Батням овогтой Тэмүгэ (РД: УХ92030472)-г 2018 оны 8 дугаар сарын 27-ны өдрөөс томилсугай.
2. Б.Тэмүгэгийн цалин, урамшууллын хэмжээг ТУЗ-ийн дэргэдэх Аудитын Хорооны саналын дагуу тогтоохыг зөвшөөрсүгэй.
3. Компанийг төлөөлж Дотоод аудитортой хөдөлмөрийн гэрээ болон нууцлалын гэрээ байгуулахыг ТУЗ-ийн Дарга /О.Болдбаатар/-т даалгасугай.
4. Дотоод аудиторын чиг удирдлагаар ханган, үйл ажиллагаа, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хороо /дарга Ж.Жаргалсүрэн/-д үүрэг болгосугай.
5. Энэхүү тогтоолын биелэлтийг хангуулах ажлыг Гүйцэтгэх захирал /Б.Дэлгэржаргал/-д даалгасугай.

ТУЗ-ИЙН ДАРГА



О.БОЛДБААТАР